бүтэн люкс	全デラックス
бүхий	全ての、～のある
давхар	階
дээд зэрэглэл	高級
ерөнхийлөгч	大統領
зориулалт	目的、目標
зэрэглэл	等級
иж бүрэн	完全な
интернет	インターネット
морил-	いらっしゃる（「行く、来る」の（敬語））
нэг ортой өрөө	シングルベツトルーム
од	星
олон улсын	国際的
өндөр хурд	高速
ресторан	レストラン
салбар	支店
семинар	セミナー
стандарт	水準、標準
та бүхэн	あなたがたみな
тавтай	快適な／に
танхим	ホール

тоноглогд-	設備される
тус	この、当該の
хагас люкс	半デラックス
хоёр ортой өрөө	ダブルベツトルーム
холгүй	遠くない
хурал	会議
хурд	速度
хүлээн ав-	受け入れる
хүчин чадал	能力
хэрэгсэл	備品、設備
цэнгэг	新鮮な、清らかな、すがすがしい
шуурхай	迅速な／に
ээлж	交替

## 第 1 1 課 (Арван нэг) 店 (Дэлгүүр)

### 会話

-Үйлчлэгч ээ. Байцаа, загасны мах хаана байна вэ?

-Хүнсний ногоо мах зүүн буланд бий.

-Нэг килограмм үхрийн мах ямар үнэтэй вэ?

-Мянган төгрөг.

-Хоёр сав сүү авах гэсэн юм. Сүү байна уу?

-Байна.

-Сүү хэд вэ?

-Таван зуун төгрөг.

-Нийт хэдэн төгрөг болж байна вэ?

-Гурван мянга хоёр зуун төгрөг.

-Хариулт мөнгөө авна уу?

\*\*\*\*\*

-Эрэгтэй хүний цув эсвэл хүрэм байна уу?

-Зөвхөн хар, хөх, шар хүрэм үлдсэн байна.

-Тэгвэл хөх хүрэм үзүүлээч.

-Энэ хаанахых вэ?

-Японых.

-Жаахан багадаж байна. Арай том размер байна уу?

-Хамгийн том нь энэ.

-Ямар байна?

-Яг таарч байна. Үүнийг авъя.

-Хямдруулж болох уу?

-Таван мянгаар буулгая.

\*\*\*\*\*

-Эмэгтэй зуны гутал, даашинз хаанаас авч болох вэ?

-Эмэгтэйчүүдийн тасагт бий.

-Яаж очих вэ?

-Цахилгаан шатаар эсвэл урсдаг шатаар гурван давхарт гарна.

-Зуны гутал үзэж болох уу?

-Бололгүй яахав. Та ямар загвараас нь сонирхож байна.

-Өндөр өсгийтэй, ул нарийн хоншоортой гутал авмаар байна.

## 語句 (1)

ав-	買う、取る
арай	少し
багад-	小さすぎる
байцаа	キャベツ
бололгүй яахав	勿論いいです (直訳：いけないでどうしようか)
буулга-	下げる
гар-	のぼる
гутал	靴
даашинз	ドレス (薄地の布で作った単衣の)
жаахан	少し
загас	魚
загвар	見本、デザイン
килограмм	キログラム
мах	肉



нарийн	細かい
нийт	全部、全体
өсгий	かかと
размер	サイズ、寸法
сав	容器
сонирх-	興味がある
сүү	乳、ミルク
таар-	ぴったりする
тэгвэл	それでは
ул	靴底
урсдаг шат	エスカレーター
үлд-	残る
үнэтэй	高い（値段が）
үүнийг	これを（энэ の対格）
үхэр	牛
хаанахых	どこのもの
хариулт мөнгө	お釣り
хоншоор	（靴の）つま先
хөх	青い
хүнсний ногоо	野菜
хүрэм	（短い）ジャケット
хямдруул-	安くする
цахилгаан шат	エレベーター

цув	マント、レインコート
шар	黄色い
эмэгтэйчүүдийн тасаг	婦人コーナー（売り場）
эрэгтэй хүн	男性、紳士
яг	ちょうど

## テキスト

Их дэлгүүрийн нэгдүгээр давхарт хүнсний тасаг бий. Энд байцаа, төмс, лууван, манжин зэрэг хүнсний ногоо, цай, сүү, жимс, шар айраг, архи, дарс, өндөг, чихэр, шоколад, цэвэр ус, ундаа, будаа, гурил, хонь, үхрийн мах, хиам худалдана. Хүнсний ногоог голдуу килограммаар савладаг. Харин махыг хөлдөөж граммлан боодог. Сүүг цаасан савтай зардаг. Хоолны өмнө хойно уух янз бүрийн дарс, виски, шар айраг том жижиг лонхтой байдаг. Хоёрдугаар давхарт үнэртэн, гоо сайхан, цэцэг, нүдний шилний тасаг бий. Гуравдугаар давхарт ноосон эдлэл, эрэгтэй, эмэгтэй болон хүүхдийн бэлэн хувцас, цахилгаан бараа номын тасаг байрлана. Тус их дэлгүүр баярын өдрүүдэд хямдралтай худалдаа зарладаг. Мөн байнгын үйлчлүүлэгчид хөнгөлөлт, урамшуулал эдлэх боломжтой. Өвөл монгол нэрийн ноолууран эдлэлийн бүтээгдэхүүнийг зарж борлуулдаг. Зуны цагт монгол үндэсний хувцас их эрэлттэй байдаг.

## 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Их дэлгүүрийн хэддүгээр давхарт хүнсний тасаг бий вэ?

.....

2/ Юуг голдуу килограммаар савладаг вэ?

.....

3/ Харин юуг хөлдөөж боодог вэ?

.....

4/ Сүүг юутай зардаг вэ?

.....  
5/ Тус их дэлгүүр баярын өдрүүдэд ямар худалдаа зарладаг вэ?  
.....

6/ Өвөл юуг зарж борлуулдаг вэ?  
.....

7/ Зуны цагт юу их эрэлттэй байдаг вэ?  
.....

(2) 問いの求めるものの名前をあげなさい。

1/ Хүнсний тасагт худалдах барааг нэрлэ.  
.....

2/ Хүнсний ногоог нэрлэ.  
.....

3/ Хоёрдугаар давхрын тасгуудыг нэрлэ.  
.....

4/ Гуравдугаар давхрын тасгуудыг нэрлэ.  
.....

(3) 語を補いなさい。

1/ Хоолны.....хойно..... янз .....дарс, ....., шар..... том ..... лонхтой  
.....

2/ .....байнгын ..... хөнгөлөлт..... эдлэх.....

語句 (2)

архи

酒

байнгын

いつもの、常時の

байрла-	位置を占める
баяр	祝い
боломжтой	～でありうる
боо-	包む
борлуул-	売る、転売する
будaa	穀物、穀類
бүтээгдэхүүн	生産品
бэлэн хувцас	既製服
виски	ウイスキー
гоо сайхан	美容
граммла-	グラムではかる
гурил	小麦粉
дарс	果実酒
жимс	果実
зар-	使う
зарла-	広告する
лууван	かぶら、人参
манжин	甜菜、蕪
монгол нэрийн	モンゴル名の
ноолуур	綿毛、柔毛、カシミヤ
ноосон эдлэл	ウール製品
нүдний шил	眼鏡
өмнө	前
өндөг	卵

савла-	容器に入れる
тасаг	売り場
төмс	ジャガイモ
урамшуулал	激励、インセンティブ
үйлчлүүлэгч	客
үндэсний хувцас	民族服
үнэртэн	香水
үхрийн мах	牛肉
хиам	腸詰め
хойно	後
хонь	羊
хөлдөө-	冷凍する
хөнгөлөлт	軽減、緩和、ディスカウント
худалд-	売る、商いする
худалдаа	販売
хямдрал	値下げ
цаас	紙
цахилгаан бараа	電化製品
цэвэр ус	清らかな水、ミネラルウォーター
чихэр	砂糖、飴、キャンディ
шоколад	チョコレート
эдэл-	使う、受ける
эдлэл	品物、製品
эрэлт	需要、要請

## 第 1 2 課 (Арван хоёр) レストラン (Зоогийн газар)

### 会話

-Та юу захиалах вэ?

-Ундаа, уух зүйл юу байна?

-Манайд цай, ундаа, дарс байна.

-Халуун цай нэг аяга авч болох уу?

-За одоохон авчирч өгье.

-Ямар хоол байна вэ?

-Бууз, хуушуур, цуйван, ногоотой хуурга байна.

-Ногоотой шөл байна уу?

-Байхгүй. Уучлаарай.

-Өөр ямар шөл байна вэ?

-Пүнтүүзтэй шөл байна. Та авах уу?

-Нэг тавгийг авъя. Баярлалаа.

-Тооцоогоо хийх гэсэн юм.

-Бүгд таван мянган төгрөг болж байна.

\*\*\*\*\*

-Зөөгч өө. Шар айраг нэг шил авъя.

-Боргио шар айрагнаас уу?

-Тиймээ.

-Нэг шил дарс, хоёр зуун грамм архи авч болох уу?

-Ямар дарс, ямар архи байна вэ?

-Усан үзэмний дарс, цагаан архи байна.

-Та монгол дарс авчирч өгнө үү?

-Тэгэлгүй яхав. Та түр хүлээж байгаарай.

-Ууцгаая найз аа. Тогтооё.

-Эрүүл энхийн төлөө.

## 語句 (1)

авчирч өг-	持ってきてあげる
аяга	椀、杯
байхгүй	ありません、ない
бууз	蒸した肉饅頭
бүгд	すべて、みな
грамм	グラム
захиал-	注文する
зөөгч	給仕
манайд	私達のところに
ногоотой хуурга	野菜入りの肉いため
ногоотой шөл	野菜入りスープ
нэг шил	一本（瓶）
пүнтүүзтэй шөл	春雨入りスープ
тогтооё	乾杯しましょう
тооцоо хий-	勘定を済ます
төлөө	～のために
тэгэлгүй яахав	勿論そうします
усан үзэм	ブドウ
уух зүйл	飲むもの
уучлаарай	すみません
халуун	暑い、熱い
хуушуур	揚げた肉饅頭

хүлээ-	待つ
цагаан архи	モンゴル製のウオッカ
цуйван	蒸し焼きうどん
шөл	スープ、汁
эрүүл энх	健康

## テキスト

Монголчууд малын мах сүү шимийг боловсруулж хоол бэлтгэнэ. Монголчууд малын их бие, зүрх, уушиг, элэг, бөөр, ходоод, гэдсийг давс, сонгино, сармис, халуун ногоогоор амталж, махан хоол хийдэг. Мөн тураг махыг томоор хөшиглөөд, давс сонгиноор хачирлаж, саванд улайтгасан чулуутай хийж жигнээд, хорхог шөлийг болгодог. Монголчуудын чухал хоол хүнс бол цагаан идээ билээ. Цагаан идээнд ааруул, аарц, айраг, бяслаг, өрөм, тараг, хоормог, хутгамш, хурууд, хуурай сүү, цагаа, цагаан тос, шимийн архи, ээдэм, ээзгий зэрэг малын сүүгээр хийсэн бүтээгдэхүүн багтана. Монгол хүний идээ ундааны дээд нь таван хошуу малын маань сүү юм. Таван хошуу малын сүү дор бүрдээ өвөрмөц. Хонины сүүг тослог ихтэй, чихэрлэг, сүлрэх чанараар илүү гэж үзнэ. Ямааны сүүг шингэн, тослог багатай сүлрэх нь хониныхоос дутуу гэж үзнэ.

## 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Монголчууд юуг боловсруулж хоол бэлтгэх вэ?

.....

2/ Хорхог шөлийг хэрхэн хийж болгодог вэ?

.....

3/ Хонины сүүг юу гэж үзэх вэ?

.....

4/ Ямааны сүүг юу гэж үзэх вэ?

.....



5/ Монгол хүний идээ ундааны дээд нь юу вэ?

.....

(2) 問いの求めるものの名前をあげなさい。

1/ Махан хоол хийдэг малын эрхтнийг нэрлэ.

.....

2/ Махан хоолны амтлагчийг нэрлэ.

.....

3/ Цагаан идээг нэрлэ.

.....

(3) 語を補いなさい。

1/ Монголчуудын..... хоол..... бол..... идээ.....

2/ ..... хошуу.....сүү..... бүрдээ.....

## 語句 (2)

ааруул	アーロール (乾酪)
аарц	アールツ (チーズの一種)
амтал-	味付けする
бага	少ない
багт-	入る
болго-	料理する
боловсруул-	加工する、精製する
бөөр	腎臓
бяслаг	チーズ
гэ-	～という

гэдэс	腹
давс	塩
дор бүрдээ	個々に、それぞれに
дутуу	足りない
дээд	最上 (のもの)
жигнэ-	蒸す
зүрх	心臓
идээ	食物
илүү	余計に
их бие	胴体
мал	家畜
махан хоол	肉の食事
өрөм	ウルム (熱したミルクの表面の薄膜から作る乳製品の1種)
сармис	ニンニク
сонгино	葱
сүлэр-	乳の味がする
сүү шим	乳、ミルク
таван хошуу мал	五種の家畜 (馬、牛、らくだ、羊、山羊)
тараг	ヨーグルト
тослог	脂肪、脂っこい
тураг мах	ヒレ肉
улайтга-	赤くする、赤熱する
уушиг	肺

халуун ногоо	香辛料、薬味
хачирла-	つけ合わせる
ходоод	胃
хоормог	ホールモッグ (乳とタラグかアイラグとを混ぜ合わせたヨーグルトの1種)
хорхог	ホルホッグ (焼いた石で作る焼肉料理)
хөшиглө-	切り刻む
хутгамш	新鮮なクリームと混ぜ合わせた粉状のエーズギーかアーロール
хурууд	硬い乾燥チーズ
хуурай сүү	粉ミルク
цагаа	一度煮立てた凝乳
цагаан идээ	乳製品
цагаан тос	バター
чанар	質
чихэрлэг	砂糖っぼい
чулуу	石
шим	栄養分
шимийн архи	家畜の乳から作った蒸留酒
шингэн	薄い
элэг	肝臓
ээдэм	凝固乳
ээзгий	凝乳
ямаа	山羊

## 第 13 課 (Арван гурав) 郵便、通信 (Шуудан, холбоо)

### 会話

-Сайн байна уу?

-Сайн. Танд юугаар туслах вэ?

-Илгээмж явуулах гэсэн юм.

-Хаашаа?

-Япон руу.

-Япон руу нэг килограмм ачаа ямар үнэтэй вэ?

-Үнийн жагсаалтаас харна уу?

-Та ачаагаа жигнүүлээд, гаальд шалгуулах ёстой.

-За ойлголоо.

-Та очих болон буцах хаягаа бичнэ үү?

-За одоохон.

-Энэ ачаа Япон улсад хэдий хугацаанд очих вэ?

-Хоёр долоо хоногийн дотор очно.

-Хэдэн төгрөг төлөх вэ?

-Мянган төгрөг болж байна.

-Их баярлалаа.

-Ажлын амжилт хүсье.

\*\*\*\*\*

-Байна уу?

-Байна. Хэн бэ?

-Би Бат байна.

-Би Дорж байна.

-Чи завтай бол үдээс хойш уулзаж гадуур явах уу?

- Тэгье.
- Хаагуур явах вэ?
- Хоёулаа эхлээд үндэсний зургийн үзэсгэлэн үзье.
- Дараа нь яах вэ?
- Орой хамт япон зоогийн газар хоол идье.
- Чи ямар япон хоол идмээр байна вэ?
- Би салат, цагаан будаа, загасны шөлд дуртай.
- За. Зөвшөөрч байна.
- Таван цагт танай ажлын газрын үүдэнд уулзъя.
- Чи миний гар утас руу залгаарай.
- Тэгэлгүй яахав. Утасны дугаар чинь хэд билээ?
- 88-86-04-95
- Баярлалаа. Түр баяртай.

## 語句 (1)

ажил	仕事
ажлын газар	勤務先、職場
ачаа	荷物
байна уу	もしもし (電話で)
буцах хаяг	返送先
гадуур	外に
гар утас	携帯電話
жагсаалт	表 (ひょう)
жигнүүл-	重量を測ってもらう

зөвшөөр-	認める、賛成する
илгээмж	小包
очих хаяг	あて先
салат	サラダ
тэг-	そうする
үзэсгэлэн	展覧会、展示会
үүд	ドア、門
хаагуур	どこを
хаашаа	どこへ
хар-	見る、眺める
хоёулаа	二人一緒に
хугацаа	期間
хэдий	どれほど
цагаан будаа	お米
шалгуул-	検査を受ける
эхлээд	初めに

## テキスト

Хүмүүс баяраар бие биедээ мэндчилгээ дэвшүүлж, ил захидал илгээдэг. Ил захидал нэг ба хоёр хуудастай байж болно. Хоёр хэсгээс бүрдсэн ил захидлын хуудсыг дугтуйнд хийдэг. Шуудангийн ил захидлын хуудсанд багтах мэдээлэл, бичиг, ном хэвлэлээс хэсэглэн авсан зүйл, гар ба гэрэл зургийг нааж болно. Ил захидлын хуудас захидлын дугтуйны хэмжээнд таарах ёстой. Ил захидал үндэсний түүх, соёл, зан заншил, байгаль, ан амьтан зэрэг төрөл бүрийн сэдэвтэй байна. Олон нэр төрлийн, өнгө загвартай ил захидал, мэндчилгээг захиалгаар хэвлэнэ. Зарим хүн гараар ил захидал урладаг. Гараар урласан ил захидал содон сонин бэлэг, хүндэтгэл болно. Ил захидал гараараа урлахад гоёмсог цаас, үзэг, хайч, цавуу байхад л хангалттай. Ил захидал халуун дулаан үгийг дамжуулахаас гадна өвөрмөц амттай байж болно. Сайхан идэж болдог ил

захидлыг бүтээжээ. Иддэг ил захидал тус тусын онцлог амттай тул амтыг нь сонгох боломжтой ажээ.

## 練習問題

### (1) 問いに答えなさい。

1/ Ил захидал хэдэн хуудастай байж болох вэ?

.....

2/ Юуг дугтуйнд хийдэг вэ?

.....

3/ Ямар ил захидал мэндчилгээг захиалгаар хэвлэх вэ?

.....

4/ Зарим хүн гараар юу урладаг вэ?

.....

5/ Юу сонин содон бэлэг, хүндэтгэл болох вэ?

.....

### (2) 語を補いなさい。

1/ Шуудангийн .... захидлын ..... багтах ....., бичиг, .....хэвлэлээс

..... авсан ....., гар..... гэрэл ..... нааж .....

2/ .....захидлын..... захидлын ..... хэмжээнд ..... ёстой.

3/ Ил ..... үндэсний ..... соёл, ..... заншил, ....., ан ..... зэрэг .....

бүрийн..... байна.

4/ ..... ил ..... тус ..... онцлог ..... тул ..... сонгох ..... ажээ.

### (3) 語を正しく配列しなさい。

1/ гадна, захидал, дамжуулахаас, болно, амттай, халуун, үгийг, байж, ил,

дулаан

.....  
2/ бүтээжээ, идэж, болдог, захидлыг, болдог, сайхан, ил  
.....

## 語句 (2)

амт	味
ан амьтан	動物
бие биедээ	お互いに
бүрд-	成る
бүтээ-	つくる
бэлэг	贈り物
гадна	他に
гар	手
гар зураг	線描、図画
гоёмсог	美しい
гэрэл зураг	写真
дамжуул-	伝える
дугтуй	封筒
дэвшүүл-	ささげる
зан заншил	習慣
захиалга	注文
захидал	手紙
ил захидал	ハガキ
илгээ-	送る



МЭДЭЭЛЭЛ	情報、知らせ
МЭНДЧИЛГЭЭ	挨拶
наа-	貼る
нэр төрөл	種類
ОНЦЛОГ	特徴
СОДОН	変わった
СЭДЭВ	主題
таар-	ぴったりと合う
төрөл бүрийн	あらゆる種類の
тус тусын	各々の
урла-	巧みに作る
ҮГ	言葉
хайч	はさみ
хангалттай	満足のいく
хуудас	ページ
ХҮМҮҮС	人々
ХҮНДЭТГЭЛ	尊敬
ХЭВЛЭ-	出版する
ХЭВЛЭЛ	出版、印刷
ХЭМЖЭЭ	規格
ХЭСЭГЛЭ-	小分けにする
цавуу	糊
шуудан	郵便

第 1 4 課 (Арван дөрөв) 理髮店、靴修理、ドライクリーニング  
(Үсчин, гутал засвар, хими цэвэрлэгээ)

会話

-Сайн байна уу? Та үсээ яаж засуулах вэ?

-Үсээ богино тайруулаад, угаалгах гэсэн юм.

-За ямар маягаар засуулах вэ? Энэ зургаас сонгоно уу?

-Ингэж засуулъя.

-Урдаас нь нэлээд, хоёр хажуунаас бага зэрэг аваарай.

-За таны үс их шингэн юм. Тиймээс урдаас тайрахгүй бол болохгүй.

-Та өөрөө мэд дээ.

-Та эмчилгээний шампуниар үсээ угааж байгаарай.

-За ойлголоо.

\*\*\*\*\*

-Уучлаарай. Гутлаа засуулах гэсэн юм.

-Яаж засуулах вэ?

-Миний гутлын өсгий уначихлаа.

-За. Эхлээд зузаан ул тавьж наах уу?

-Үгүй. Өсгий хадаж өгнө үү?

-Эхэлж оёод хадъя.

-Хэзээ бэлэн болох вэ?

-Дөрвөн цагийн дараа бэлэн болно.

\*\*\*\*\*

-Би хэдэн хувцас цэвэрлүүлмээр байна.

-Хэдэн хувцас вэ?

-Хоёр цамц нэг өмд.

-Цамцны толбо арилах уу?

-Арилах боломжтой.

-Тасалбараа авна уу?

-За.

-Яаралтай бол маргааш ирж хувцсаа аваарай.

## 語句 (1)

арил-	きれいになる、(汚れが) 落ちる
бага зэрэг	少しばかり
богино	短い
болохгүй	いけない、ならない
бэлэн	準備ができた
засуул-	直してもら、整えてもら
зузаан	厚い
ингэ-	こうする
маргааш	明日
маяг	形、～風
наа-	貼る、貼りつける
өмд	ズボン
өөрөө	自分自身
тавь-	置く
тайр-	刈る
тайруул-	刈らせる、刈ってもら
тасалбар	クーポン、レシート
тиймээс	だから
толбо	シミ、汚れ
угаалга-	洗ってもら

ул	足底、靴底
уна-	落ちる
урд	前
үс	髪
хад-	(釘などを) 打ち込む
хадаж өг-	(釘などを) 打ち込んでくれる
хажуу	側
цамц	シャツ
шампунь	シャンプー
эмчилгээ	治療
эхлээд	始めに
яаралтай	急いだ

## テキスト

### 理髪店 (Үсчин)

Үсчин үс засах, үс хэлбэртэй засах, үс тайрах, үс хэлбэртэй тайрах, урт богино үс сэнсдэх, үс угаах, үс тослох, үс индүүдэх, үс сүлжих, үс будах зэрэг олон үйлчилгээ үзүүлнэ. Бас хөл, гарын хумс засал, нүүрний арьс, бүтэн биеийн арьс арчилгаанаас гадна хөмсөг шивэх, толгой хүзүүний чилээг тайлах, биеийн арьс гуужуулах, нүүр чийгшүүлэн толийлгох гэх мэтээр гоо сайхны цогц үйлчилгээ ч бий. Үс сайхан бол зүс сайхан. Үс цэвэр өнгөлөг байхыг хүн бүхэн хүснэ. Үсийг хүний нүүр царайны хэлбэр, зан чанарт тохируулж тайрна. Аливаа засалт хүнд зохино. Эмэгтэйчүүдэд бага зэрэг долгионтой, дундаж урттай, хөвсгөр үс зохино. Харин эрэгтэйчүүдэд хурц өнцөг гаргаж, захалсан үс тохирно.

### 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Үсийг юунд тохируулж тайрах вэ?

.....

2/ Эмэгтэйчүүдэд ямар үс зохих вэ?

.....

3/ Эрэгтэйчүүдэд ямар үс зохих вэ?

.....

(2) 問いの求めるものの名前をあげなさい。

1/ Үсчний үйлчилгээг нэрлэ.

.....

2/ Гоо сайхны үйлчилгээг нэрлэ.

.....

(3) 適切な問いを作りなさい。

1/.....?

Үс сайхан бол зүс сайхан.

2/.....?

Үс цэвэр өнгөлөг байхыг хүн бүхэн хүснэ.

3/.....?

Аливаа засалт хүнд зохино.

## 語句 (2)

арчилгаа                      世話、気遣い

арьс                              皮膚、皮

буд-                              塗る

бүтэн                            完全な

бүхэн                            全て

гадна                            ほかに

гарын хумс засал	手の爪の手入れ
гуужуул-	脱毛させる
ГЭХ МЭГ	など
долгион	波
дундаж	平均の
зан чанар	性質
зас-	直す、整える
засалт	調整
захал-	手入れをする
зохь-	合う、適する
зүс	顔色
индүүд-	アイロンをかける
өнгөлөг	色艶のある、美しい
өнцөг	かど、隅
сүлж-	編む
сэнсд-	ファンで整える
тайл-	とく、ほぐす
тайр-	切り取る、刈る
толгой	頭
толийлго-	滑らかにする
тосло-	油をつける
тохир-	一致する、適合する
тохируул-	合わせる
урт	長い
үзүүл-	見せる、与える、する

үйлчилгээ	サービス
үсчин	理髪店、理髪師
хөлийн хумс засал	足の爪の手入れ
хөвсгөр	やわらかい
хөмсөг	眉毛
хурц	鋭い
хүзүү	首、うなじ
хэлбэр	形
цогц	複合体、構成
цэвэр	きれいな
чийгшүүл-	湿気を与える
чилээ	疲れ
шив-	ちくりと刺す
эмэгтэйчүүд	女性たち
эрэгтэйчүүд	男性たち

## 第 1 5 課 (Арван тав) 天候、四季 (Цаг агаар, дөрвөн улирал)

### 会話

-Өнөөдөр гадаа ямар байна?

-Маш хүйтэн байна.

-Шөнөдөө хасах гучин хэм хүрсэн гэнэ.

-Маргааш цаг агаар ямар байх вэ?

-Цастай гэсэн.

-Цас орж гол хөлдөхөөр тэшүүрээр гулгамаар байна.

-Ирэх долоо хоногт цасан шуурга шуурна гэж сонслоо.

-Ойрдоо тэнгэр муухай байна.

-Бушуухан дулаараасай.

\*\*\*\*\*

-Хавар болж голын мөс хайлж газар гэсчээ.

-Ууланд хавар нэлээд жиндүү шүү.

-Говьд хаврын хавсарга шороо шуурдаг.

-Хангай нутагт зун сэрүүхэн үү?

-Сэрүүн өдөр олон.

-Говьд зун халуун уу?

-Тийм ээ. Зундаа халуун, өдөртөө нэмэх гучин таван хэм хүрдэг.

-Хангайд бороо их ордог байх аа?

-Зун их бороошно.

-Өвс ногоо ургаж, нар гарах ч сайхан даа.

-Зуны өглөө ойгоор алхах юм сан.

-Харин хангайд намар их богинохон.

-Гэхдээ ургац хураалт гээд та нар завгүй байдаг байх.

-Бас өвлийн бэлтгэлээ базаана.

-Модны навч шарлах жаахан уйтгартай . Тийм ээ?



- Би намрыг зураг шиг үзэсгэлэнтэй гэж боддог.
- Манай тал нутагт намар гурван сар үргэлжилдэг.
- Нээрэн говьд өвөл их удаан хүйтэн гэсэн.
- Гэхдээ говьд өвөл цас бага ордог.

## 語句 (1)

базаа-	準備する
богинохон	短い
бод-	考える
бороо ор-	雨が降る
бороош-	雨模様になる
бушуухан	すばやく
гадаа	外
газар	土地、地面
гар-	出る、のぼる
ГОВЬ	ゴビ (乾燥した砂礫性の硬い土地)
гол	河、川
гулга-	滑る
гэс-	(雪、氷などが) 融ける
дулаар-	暖かくなる
жиндүү	冷え冷えした
завгүй	忙しい
ирэх долоо хоног	来週
муухай	悪い
навч	葉

нар	太陽
ногоо	草、牧草
нутаг	故郷、地方
нэмэх	加える、プラス
нээрэн	本当に
мод	木、林
ой	森、森林
ойрдоо	最近
өвс	草
өнөөдөр	今日
сэрүүхэн	いくらか涼しい
тал	平地
тэнгэр	天、天気
тэшүүр	スケート
удаан	長い（あいだ）
уйтгартай	憂鬱な
урга-	生える
ургац хураалт	収穫
үргэлжил-	続く
хавар	春
хайл-	とける
хавсарга	（春の）突き刺すような冷たい風
хангай	ハンガイ、快適な気候で森や山が多く、河川に富む肥沃な土壌の高原状の土地
хасах	減ずる、マイナス

хөлд-	凍る
хүйтэн	寒い
хүр-	至る、達する
хэм	度 (温度の)
цаг агаар	天候
цас	雪
цас ор-	雪が降る
цасан шуурга	吹雪
шарал-	黄色くなる
шороо	土、埃
шуур-	(嵐が) 吹き荒れる

## テキスト

### 天気予報 (Цаг агаарын мэдээ)

Зүүн зүгийн нутгаар багавтар үүлтэй. Бусад нутгаар үүлшинэ. Баруун зүгийн нутгийн зарим газраар цас орж, цасан шуурга шуурна. Бусад нутгаар цас орохгүй. Салхи баруун өмнөөс секундэд 6-11 метр хүрнэ. Баруун зүгийн нутаг болон говийн бүс нутгийн зарим газраар секундэд түр зуур 16 метр хүрч ширүүснэ. Увс нуур болон Дархадын хотгороор, сав газраар 11-16 хэм, Идэр, Тэс, Ерөө, Эг-Үүр, Орхон, Сэлэнгэ, Хараа, Туул, Тэрэлж голын сав газраар 7-12 хэм хүйтэн, Онон, Улз, Халх голын сав газраар 3-8 хэм хүйтэн байна. Говийн бүс нутгийн өмнөд хэсэг болон цас багатай нутгуудаар шөнөдөө 1-6 хэм дулаан байна. Бусад нутгаар өдөртөө 2 хэм дулаанаас 3 хэм хүйтэн байна.

### 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Хаагуур цас орж цасан шуурга шуурах вэ?

2/ Бусад нутгаар яах вэ?

3/ Юу баруун өмнөөс секундэд 6-11 метр хүрэх вэ?

(2) 語を補いなさい。

1/ Баруун..... нутаг болон ..... бүс ..... зарим газраар .....түр зуур

16 .....хүрч .....

2/ .....нутгаар ..... 2 хэм ..... 3 ..... хүйтэн.....

(3) 次の数を文字で書きなさい。

1/ 11.....

2/ 16.....

3/ 3-8.....

4/ 9-12.....

5/13-15.....

## 語句 (2)

багавтар           ほんの少し

бусад               他の

бүс нутаг           地帯、地域

гол                  川

зүг                  方向、方角

метр                メートル

өмнө                南、前

өмнөд              南の

сав газар          流域

салхи              風

секунд             秒

түр зуур	しばらく
үүл	雲
үүлш-	曇る
хотгор	くぼ地、くぼんだ
ширүүс-	激しくなる

## 第 16 課 (Арван зургаа) 劇、娯楽、図書館 (Жүжиг, үзвэр, номын сан)

### 会話

-Энэ ямар нэртэй жүжиг вэ?

-Данзанравжаагийн зохиосон “Саран хөхөө” гэдэг жүжиг.

-Энэ жүжиг ямар сэдэвтэй вэ?

-Варанаси хотын ханхүү хөхөө болсон тухай гардаг.

-Хөхөө ном номлодог бил үү?

-Тийм.

-Жүжгийн гол дүрд хэн тоглож байна вэ?

-Саранхөхөөгийн дүрд жүжигчин Болд тоглож байна.

-Найруулагч нь хэн бэ?

-Баатар гуай.

-Хэддэх өдөр тоглох вэ?

-Нэгдэх өдөр арван найман цагаас тоглоно гэнэ.

\*\*\*\*\*

-Чи ямар ном уншиж байна вэ?

-Би “Монголын нууц товчоо” зохиол уншиж байна.

-Чингис хааны тухай зохиол биз дээ?

-Тийм. Монголын их гүрний түүхийн ном.

-Чингис хаан ямар хүн бэ?

-Чингис хаан арван гуравдугаар зууны монголын баатар хүн.

-Би ч гэсэн энэ баатрын тухай уншмаар байна.

-Олж уншаарай.

## 語句 (1)

баатар	英雄
биз дээ	きっと～でしょうね
бил үү	～だったかな
гол	主な、中心
гуай	～さん
гүрэн	国家
дүр	役
жүжиг	劇
жүжигчин	俳優
зохио-	作る
зохиол	作品
найруулагч	演出家
номло-	説教する
нууц	秘密
ол-	見つける
товчоо	概要
тухай	～について
ханхүү	王子
хөхөө	かつこう

## テキスト

### ボグドハーン宮殿博物館 ( Богд хааны ордон музей )

Халхын наймдугаар богд Жавзандамба хааны амьдарч байсан өргөө долоон ордноос бүрдэнэ. Энэ ордон музейд муу ёрын сүнсээс хамгаалсан хаалттай хаалга буюу Янпай хаалга, Богд хаан болон түүний хатан, садан төрлийн

хүмүүс нь ордог нээлттэй хаалга буюу Асарт хаалга байдаг. Мөн найман багана, долоон давхар дээврээс бүрдэх нэг ч хадаас хэрэглэлгүйгээр 108 төрлийн оньсоор угсарсан Амгалан энхийн хаалга ч бий. Энэ хаалгыг Жавзандамба хутагтыг хаанаар өргөмжилсөн үйл явдалд зориулж барьсан юм.

Богдын музейд Махранзын сүм, Равса буюу сэрүүн асар, Торгон зургийн сүм, Уран зургийн сүм, Найдан сүм, Бурхны сүм, Лаврин сүм гэсэн зургаан сүм нэг асар бий. Богд хааны өвлийн ордон бол тухайн үедээ монголд хамгийн анхны европ загвараар баригдсан барилга ажээ. Богд хаан, түүний хатан Дондогдулам нарын хэрэглэж байсан эд өлөг, хувцас хэрэглэлийг одоо үзмэр болгожээ.

## 練習問題

### (1) 問いに答えなさい。

1/ Юу долоон ордноос бүрдэх вэ?

.....

2/ Юуг одоо үзмэр болгосон бэ?

.....

### (2) 問いの求めるものの名前をあげなさい。

1/ Богдын музейн хаалгануудыг нэрлэ.

.....

2/ Богдын музейн сүмүүдийг нэрлэ.

.....

### (3) 語を正しく配列しなさい。

1/ барьсан, энэ, хутагтыг, энэ, хаанаар, хаалгыг, явдалд, өргөмжилсөн, явдалд, зориулж, үйл, Жавзандамба, юм

.....

2/ хамгийн, үедээ, баригдсан, европ, хааны, ордон, тухайн, монголд, анхны, загвараар, барилга, Богд, ажээ, өвлийн, бол

.....



## 語句 (2)

амгалан	平和な、平穩な
асар	大天幕
багана	柱
баригд-	建てられる
барилга	建物
барь-	建てる
богд	聖なる
болго-	～にする
бурхан	仏、仏陀
давхар	層、二重の
дээвэр	屋根
европ	ヨーロッパ
зориул-	向ける、ささげる
музей	博物館
муу ёр	悪い予兆
нэг ч	一つも
нээлтэй	開いた
оньс	差し錠、かんぬき
ордон	宮殿
өргөмжил-	位を授与した
өргөө	宮殿、王宮

садан	親族、親戚
сүм	寺
сүнс	靈
торго	絹
төрөл	種類
тухайн үе	その頃
угсар-	組み立てる、連結する
уран зураг	絵画
үзмэр	展示品、陳列品
үйл явдал	事柄、行為
хаалга	門
хаалттай	閉じた
хаан	ハーン、王
хадаас	釘
хамгаал-	守る
хатан	王妃
хутагт	卓越した活仏に授けられる最高の僧の称号
хэрэглэ-	利用する
хэрэглэл	用具、装身具
эд өлөг	物品
энх	平和な

## 第 17 課 (Арван долоо) 病院、薬局 (Эмнэлэг, эмийн сан)

### 会話

-Сайн байна уу?

-Би ходоодоо үзүүлэх гэсэн юм.

-Бие чинь яаж байна вэ?

-Дотор муухайраад байна.

-Хоолны дуршил хэр байна?

-Зүгээр.

-Энд өвдөж байна уу?

-Үгүй гайгүй.

-Амаа ангайж, хэлээ гаргана уу?

-Халуунтай байна уу?

-Тийм. Халуурч байна.

-Та шинжилгээ өгч, гэрэлд харуулах хэрэгтэй.

-Хариу тааруу гарвал яах вэ?

-Хэвтэж эмчлүүлэх шаардлагатай.

-Амьсгаа гүнзгий аваарай.

-Жаахан хүлээнэ үү? Танд ходоодны эм бичиж өгье.

-Баярлалаа эмч ээ.

-Баяртай түргэн эдгээрэй.

\*\*\*\*\*

-Эмийн сан хаана вэ?

-Эмнэлгийн баруун талд жижиг цагаан байшин бий.

-Эмийн жороо хаана өгөх вэ?

-Хүлээн авахад өгнө үү.

-Энэ эмийг яаж уух вэ?

-Хоолны дараа өдөрт хоёр удаа ууна.

## 語句 (1)

ам	口
амьсгаа	呼吸
ангай-	開ける
байшин	建物、固定家屋
гайгүй	大丈夫、なんでもない
гүнзгий	深く
гэрэл	光、光線
дотор муухайр-	吐き気を催す、気持ちが悪くなる
зүгээр	なんともない、大丈夫
өвд-	痛む
тааруу	悪い
түргэн	速い
үзүүл-	見てもらう
халуун	熱
халуур-	熱がある、熱が出る
хариу	答え
харуул-	調べてもらう
хоолны дуршил	食欲
хүлээн авах	受付、受け取る
хэвт-	横になる、病気で寝ている

хэл гарга-	舌を出す
хэр	いかが
хэрэгтэй	必要な
шаардлагатай	要請がある、～ねばならない
шинжилгээ	検査
эдгэ-	回復する
эм	薬
эмийн жор	処方箋
эмийн сан	薬局
эмнэлэг	病院
эмч	医者
эмчлүүл-	治療してもらう、治療を受ける
яа-	どうする

## テキスト

“Эрүүл чийрэг монгол хүн” аяны хүрээнд нийслэлийн зарим иргэнд эмнэлгийн мэргэжлийн үзлэгийг сарын турш хийжээ. Үзлэг үнэ төлбөргүй байсан ажээ. Эмч нар амин дэм тараажээ. Улаанбаатар хотын олон дүүргийн хэдэн зуун хүн дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хүүхэд, арьс өнгө, мэс засал, чих хамар хоолой, дүрс оношлогооны үзлэгт хамрагдаж, шинжилгээ, эмчилгээ хийлгэжээ. Мөн эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан нар даралт ихсэх, дотоод шүүрэл, зүрх судас, зүрхний хэм алдах, уушиг, үргүйдэл, чихрийн шижин, бөөр, нуруу нугас, хоол боловсруулах эрхтэн, харшлын өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийлээ. Эцэст нь тэд эрүүл хүнсээр хооллох, цэвэр агаарт аялах, дасгал сургууль хийж, гүйх, алхах, биеийн тамир, спортоор хичээллэхийн чухлыг онцолж байлаа.

## 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Эрүүл чийрэг монгол хүн аяны хүрээнд юу хийсэн бэ?

.....

2/ Үзлэг ямар байсан бэ?

.....

3/ Эмч нар юу тараасан бэ?

.....

(2) 問いの求めるものの名前をあげなさい。

1/ Эмнэлгийн үзлэгүүдийг нэрлэ.

.....

2/ Өвчин эмгэгүүдийг нэрлэ.

.....

(3) 語を正しく配列しなさい。

1/ спортоор, онцолж, чухлыг, хийж, нь, хооллох, эцэст, цэвэр, эрүүл, аялах, дасгал, сургууль, гүйх биеийн тамир, агаарт, алхах, хичээллэхийн, байлаа, тэд, хүнсээр

.....

## 語句 (2)

амин дэм                      命のサポート

арьс өнгө                      皮膚

аян                              旅行

биеийн тамир                体育、運動

гүй-	走る
даралт	血压
дасгал	訓練
дотоод шүүрэл	内分泌腺
дотор	内臓
дүрс оношлогоо	診断
дүүрэг	区
зүрх судас	心臓血管
зүрхний хэм алд-	不整脈になる（心臓が不規則な鼓動をする）
иргэн	公民
ихэс-	上がる、増える
мэдрэл	神経
мэс засал	手術
нуруу нугас	脊髓
онцол-	強調する
өвчин	病気
сургууль хий-	訓練をする
таниулга	説明
тараа-	広げる
турш	～の間
тэд	彼ら
урьдчилан сэргийл-	予防する
үзлэг	検査

үнэ төлбөргүй	無料
үргүйдэл	不妊
хамрагд-	包含される
хийлгэ-	してもらい、おこなってもらい
хоол боловсруул-	食物を消化する
харшил	アレルギー
хичээллэ-	訓練する
хоолло-	食事をする
чийрэг	健康な、力の強い
чих хамар хоолой	耳鼻咽喉
чихрийн шижин	糖尿病
чухал	重要
эмгэг	病気
эрүүл	健康
эрхтэн	器官



## 第 18 課 (Арван найм) ウランバートル市 (Улаанбаатар хот)

### 会話

-Чингисийн хөшөө хаана байдаг вэ?

-Чингисийн хөшөө төрийн ордны өмнө байдаг.

-Дуурь бүжгийн театр луу яаж очих вэ?

-Чигээрээ яваад зүүн тийшээ эргэнэ.

-Тэр байшин улсын номын сан мөн үү?

-Тийм ээ. Та зам хөндлөн гараад яваарай.

-Энэ гудамжийг юу гэж нэрлэдэг вэ?

-Энх тайвны өргөн чөлөө гэдэг.

-Би Японы элчин сайдын яам руу яаж явах вэ?

-Эндээс автобусаар явна.

-Явган явбал хол уу?

-“Улаанбаатар” зочид буудлын зүүн талаар алхаад, Анагаахын их сургуулийн дэргэдүүр өнгөрч очно.

\*\*\*\*\*

- Энэ Зайсан толгой дээрээс Улаанбаатар хот их тод харагдаж байна.

-Зүүнээс баруун тийш хөндлөн урссан энэ гол ямар гол вэ?

-Туул гол.

-Утаа савссан, өндөр том зуухтай барилга юу вэ?

-Дөрөвдүгээр цахилгаан станц.

-Энэ аварга том гүүрийг юу гэж нэрлэдэг вэ?

-Энх тайвны гүүр гэдэг.

-Тэр соёмбо тэмдэгтэй уул ямар уул вэ?

-Энэ бол Богд хан уул.

## 語句 (1)

аварга	巨大な
анагаахын	医科の (治療することの)
гудамж	街路
гүүр	橋
дуурь бүжгийн театр	オペラ・バレエ劇場
дэргэдүүр	そば
дээрээс	上から
зуух	炉
номын сан	図書館
нэрлэ-	呼ぶ
өнгөр-	通り過ぎる
өргөн чөлөө	大通り
савс-	立ち上る
тал	側、方面
тийш /тийшээ/	～に向かって、～の方へ
тод	はっきりと
толгой	頭、頂上
төр	政府
тэмдэг	しるし
урс-	流れる
угаа	煙

харагд-	見える、見られる
хөндлөн	横に、水平に
хөшөө	像、記念碑
цахилгаан станц	発電所
чигээрээ	まっすぐ
элчин сайдын яам	大使館
энх тайван	平和
эргэ-	回る
явган	徒歩

## テキスト

Улаанбаатар хот бол Монгол улсын нийслэл юм. Улаанбаатар хот анх 1639 онд байгуулагдсан. Урьд цагт Өргөө, Их хүрээ, Нийслэл хүрээ гэж янз бүрээр нэрлэдэг байв. Одоо сая гурван зуун мянган хүнтэй. Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул, Налайх, Багануур Багахангай зэрэг дүүрэгтэй. Улаанбаатар хот Монголын улс төр, соёл, шинжлэх ухаан, эдийн засгийн төв юм. Улаанбаатар хотод төрийн ордон, яам тамгын газар, элчин сайдын яамд, улсын төв номын сан, их дээд сургууль, их дэлгүүр, худалдаа үйлчилгээний төв, зах, төв цэнгэлдэх хүрээлэн, биеийн тамирын ордон, монгол бөхийн өргөө, олон улсын нисэх онгоцны буудал, хивсний үйлдвэр, нэхмэлийн үйлдвэр, Чингис зочид буудал, хэд хэдэн цахилгаан станц байрлаж байна. Мөн Монголын хамгийн том төмөр зам үүгээр дайран өнгөрдөг. Улаанбаатар хот Туул голын хөвөөнд, Богд хан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх гэсэн дөрвөн уулын дунд оршдог. Улаанбаатар хот улам бүр хаяагаа тэлж хөгжиж байна.

## 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Монгол улсын нийслэл ямар хот вэ?

.....

2/ Улаанбаатар хот анх хэзээ байгуулагдсан бэ?

.....  
3/ Улаанбаатар юуны төв бэ?

.....  
4/ Улаанбаатараар юу дайран өнгөрдөг вэ?

.....  
5/ Улаанбаатар хот хаана оршдог вэ?

.....  
**(2) 語を補いなさい。**

1/ Улаанбаатар .....төрийн....., яам ....., элчин сайдын ....., улсын  
төв ..... сан, их .....сургууль, их ....., худалдаа ..... төв, ....., төв  
цэнгэлдэх ....., биеийн ..... ордон, монгол ..... өргөө, олон  
улсын ..... буудал, хивсний ....., ..... үйлдвэр, Чингис .....  
буудал, ..... хэдэн .....станц ..... байна.

2/ Улаанбаатар Туул .....хөвөөнд, Богд ....., Сонгинохайрхан, .....,  
Баянзүрх гэсэн ..... уулын ..... оршдог.

**語句 (2)**

анх	最初に、始めに
байгуулагд-	建てられる、建設される
бөх	相撲
гэ-/гэж/	～という (～と)
дайр-	通りかかる
дунд	中に
дүүрэг	区、地区

дээд сургууль	大学（単科大学）
зах	市場
НИСЭХ ОНГОЦНЫ буудал	飛行場、空港
НЭХМЭЛ	織物
он	年（暦の）
орш-	位置する
өнгөр-	過ぎる
өргөө	宮殿
сая	百万
тамгын газар	役所
төмөр зам	鉄道
төр	政権、政府
тэл-	広げる、のぼす
улам бүр	益々
улс төр	国家
урьд	以前
үүгээр	これによって
хаяа	周辺、縁
хивс	絨毯
хөвөө	岸边
хөгж-	発展する
худалдаа	商業、取引
хэд хэдэн	いくつもの
цэнгэлдэх хүрээлэн	競技場、スタジアム

шинжлэх ухаан

科学、学問

яам

省

янз бүрээр

いろいろと

## 第 19 課 (Арван ес) 地方 (Хөдөө)

### 会話

-Сайхан намаржиж байна уу?

-Сайхан намаржиж байна.

-Энэ зун сайхан бороо хуртай байлаа.

-Хэлээд яах вэ?

-Зун морь уяв уу?

-Олон гүү барилаа. Айраг цагаа элбэг байна.

-Мал өсч байна уу?

-Мал гайгүй сайн өсч байна.

-Танайх бог малтай юу?

-Хонь голдуу гурван зуугаад бог бий.

-Бод малтай юу?

-Адуу үхэр нэлээд бий.

\*\*\*\*\*

-Сайхан хаваржиж байна уу?

-Сайхан хаваржиж байна.

-Онд тарган сайхан оров уу?

-Мэнд тарган орлоо.

-Мал төл арвин уу?

-Ихэр ихтэй. Төл сайн бойжиж байна.

\*\*\*\*\*

-Энэ жил ургац арвинтай юу?

-Арвин. Тариа сайн ургасан.

-Улаан буудайн гарц сайн цавуулаг их байна.

-Тариалалт хэзээ эхэлсэн бэ?

-Таван сард эхэлсэн. Нэлээд хэдэн га талбайд уринш бэлтгэсэн.

-Үр сайн сонгож авсан уу?

-Үр том байсан учраас төмс их тарилаа.

-Ямар хүнсний ногоо тарьсан бэ?

-Манай хэсэг төмс, байцаа, лууван сайн хурааж, зоорилж байна.

## 語句 (1)

адуу	馬
айраг	馬乳酒
арвин	たくさん、豊富な
бог	小型の
бог мал	小型家畜
бод мал	大型家畜
бойж-	成長する、育つ
га	ヘクタール
гайгүй	大丈夫
гарц	生産高、生産量、作柄
гүү барь-	雌馬の乳をしぼる
зоорил-	穴に入れて貯蔵する
ихэр	双子
мэнд	健やかに
морь уя-	競馬に備えて馬を訓練する
намарж-	秋を過ごす
онд ор-	(家畜が) 冬の寒さを耐えて暖かい春を迎える
өс-	育つ
талбай	場所、広場



танайх	貴方の家、貴方のところ
тарган	肥えた
тариа	穀物、農作物
тариалалт	農耕の
тарь-	種をまく、植える
төл	家畜・動物の子
улаан буудай	小麦
урга-	育つ
ургац	収穫、作物
уринш	春の開墾して植え付けの準備をした耕地
учраас	～だから
үр	種子
хаварж-	春を過ごす
хур	雨
хураа-	収穫する
цавуулаг	ねばねばする、グルテン質
цагаа	一度煮立てたヨーグルト
элбэг	豊富な
эхэл-	始まる

## テキスト

Малчин хүү Бат хар нялхаасаа тусад орно. Эцэг эхдээ тусална. Таван насандаа хонинд явж, ганцаараа хонь хариулж эхэлнэ. Их цасан дунд хонь мал төллүүлнэ. Өвөл үүрээр эртлэн босч, ууланд таран бэлчсэн сарлагийг хураана. Зун хонь хариулаад, үхэр ивэлгэж, тугал татаж өгнө. Өвөлжөө бууц янзална. Сүү цагаан идээ базаана. Ногоо тарина. Бороо орсон үед хонь манана. Үхэр бэлчээрт гарсны дараа тугалаа гаргаж бэлчээнэ. Үхрийн баас арилгана. Хурга ишгэндээ өвс тавьж өгнө. Аав, ахтайгаа хамт эмнэг хангал сургана. Хурдан морь унаж

давхина. Ээж үнээ саана. Аав морь эмээллэж, хурганы уут, шилбүүр зэхнэ. Угаасаа хөдөөний ажил их. Өглөө ургах нартай уралдан босно. Орой нар жаргахад унтана. Малчид дөрвөн улирлын аясаар таван хошуу малаа даган нүүдэллэнэ. Малчин хүний хөдөлмөр их. Малын буян ч их. Бид малын махыг идэж, арьс шир, ноосоор нь хувцас хунар хийнэ. Сүү шимийг нь идээ ундаа болгоно. Морь тэмээ үхрийг унаж, ачаа ачна. Говь нутагт жинчид тэмээгээр жин тээдэг.

## 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Малчин хүү Бат таван насандаа юу хийж эхлэх вэ?

.....

2/ Их цасан дунд юу хийх вэ?

.....

3/ Өвөл үүрээр эртлэн босч юу хийх вэ?

.....

4/ Бороо орсон үед юу хийх вэ?

.....

5/ Үхэр бэлчээрт гарсны дараа юу хийх вэ?

.....

6/ Хурга ишгэндээ юу тавьж өгөх вэ?

.....

7/ Юу унаж давхих вэ?

.....

8/ Ээж юу хийх вэ?

.....

9/ Аав юу хийх вэ?

.....

10/ Малчин хүний юу их вэ?

.....

(2) 語を補いなさい。

1/ Зун ..... хариулаад, ..... тугал ..... өгнө.

2/ Аав, ..... хамт ..... хангал .....

3/ Малчид ..... аясаар ..... хошуу ..... даган нүүдэллэнэ.

4/ Бид ..... махыг ....., арьс ....., ноосоор ..... хувцас ..... хийнэ.

(3) 語を正しく配列しなさい。

1/ нартай, босно, өглөө, ургах, уралдан

.....

2/ орой, унтана, нар, жаргахад

.....

3/ унаж, морь, ачаа, үхрийг, ачна, тэмээ

.....

4/ тээдэг, жинчид, говь, тэмээгээр, нутагт, жин

.....

語句 (2)

арилга- 掃除する、除く

арьс шир 皮革

ач- 積荷する、つむ

баас 糞

базаа- 用意する

болго- ~とする

бууц	冬の住地
буян	徳
бэлч-	草を食む
бэлчээ-	草を食ませる、放牧する
бэлчээр	放牧地
ганцаараа	ひとりで
давхи-	駆ける
дага-	従う
жарга-	(太陽が) 沈む
жин тээ-	荷を運ぶ
жинчин	隊商の人
зэх-	用意する
ивэлгэ-	乳を出させる
ишиг	子山羊
мана-	番をする
нар жарга-	日が沈む
ногоо	草
ноос	毛
нүүдэллэ-	移動する
өвөлжөө	冬営地
саа-	乳を搾る
сүү шим	ミルク
тавьж өг-	おいてやる
тар-	四散する

тарь-	植える
төллүүл-	(家畜に)子を産ませる
тугал	子牛
тугал тат-	子牛を集める
тусад ор-	(子供が)役に立つ、助けになる
тусал-	助ける、手伝う
тэмээ	ラクダ
тээ-	運ぶ、輸送する
угаасаа	もともと、元来
уралд-	競争する
ургах нар	上る太陽
уут	袋
үе	時、時代
үнээ	牝牛
үүр	曙
хариул-	放牧する
хар нялх	赤ん坊、新生児
хонинд яв-	羊の放牧に行く
хөдөлмөр	労働
хувцас хунар	衣服
хурга	子羊 (1歳羊)
хурдан	速い
шилбүүр	鞭、鞭紐
эмнэг хангал	乗りならされていない

эмнэг хангал сурга-	乗り慣らす、訓練する
эмээллэ-	鞍を置く
эртэл-	早く始める、早く何かする
эцэг эх	父母
янзал-	整える

## 第20課 (Хорь) ナーダム (祭典) (Наадам)

### 会話

-Сайхан наадаж байна уу?

-Сайхан. Та сайхан наадаж байна уу?

-Энэ жил нар хур тэгширсэн зун болж байна.

-Наадмаар бөхчүүд хүчтэй, харваачид мэргэн, морьд хурдан байна.

-Энэ цэнхэр далбаатай, улаан шуудагтай бөх хэн бэ?

-Энэ бол дархан аварга Бат Эрдэнэ.

-Тэр туг тойроод, дэвж яваа бөх хэн бэ?

-Улсын начин Багахүү.

-Монгол бөх мэх сайтай, бас хурдтай юм.

-Монгол бөхөд хэдэн зуун мэх байдаг гэдэг.

-Үндэсний бөхийн барилдаан дуусав уу?

-Дөнгөж сая дууслаа.

-Хэн түрүүлж хэн үзүүрлэсэн бэ?

-Аварга Мөнхбат, заан Санжаадамба нар түрүүлж үзүүрлэлээ.

\*\*\*\*\*

-Өчигдөр аль нас уралдсан бэ?

-Өчигдөр их нас, азарга, даага давхисан.

-Өнөөдөр ямар морь уралдах вэ?

-Өнөөдөр соёолон, хязаалан насны морь уралдана.

-Соёолон морины уралдаан үзэв үү?

-Тийм ээ. Өнөө өглөө эрт Хүй долоон худагт очиж үзлээ.

-Хэний морь түрүүлэв?

-Төв аймгийн Даваахүүгийн хээр түрүүлсэн.

-Хэний морь айрагдав?

-Булган аймгийн Маамхүүгийн цавьдар халзан аман хүзүүдэж, Цогтын хээр айрагдлаа.

-Сурын харваанд хэн түрүүлсэн бэ?

-Улсын мэргэн Хүдэрчулуун дөчин сумаас дөч онож түрүүлсэн.

## 語句 (1)

аварга	巨人、チャンピオン (モンゴル相撲の最高の位)
айрагд-	競技で首位から5位までの5頭の馬の中に入る (「馬乳酒をたくさん飲む」が原義)
аль	どれ、どの、いずれ
аман хүзүүд-	2位になる (競馬などで)
барилдаан	相撲、取り組み
бөх	力士、相撲
даага	2歳の子馬
давхи-	疾走する
далбаа	旗
дархан аварга	神聖なチャンピオン (モンゴル相撲の位)
дөнгөж	やっと
дуус-	終わる
дэв-	羽ばたく
заан	象 (モンゴル相撲の位)
их нас	長老
мэргэн	射手
мэх	技
наад-	ナーダムに参加する、遊ぶ、楽しむ



нар хур тэгшир-	太陽と雨がバランスをとる
начин	はやぶさ (モンゴル相撲の位)
оно-	命中する
очиж үз-	行ってみる
өнөө	この
өчигдөр	昨日
сая	さっき、今しがた
соёолон	5歳 (馬)
сум	矢
сур	(弓の) 的
тойр-	回る
туг	旗
түрүүл-	優勝する
улаан	赤い
уралд-	競う
уралдаан	競技
үзүүрлэ-	(相撲で) 2位になる
халзан	(家畜の) 額が白ぶちの
харваа	弓を射る能力
харваач	射手
хүчтэй	力強い
хурд	速さ
хурдтай	速い
хязаалан	(馬、牛について) 4歳の

хээр	栗毛の (馬)
цавьдар	(毛色について) たてがみと尾が白っぽく総じて栗毛色の (馬)
цэнхэр	青い、空色の
шуудаг	力士が腰につけるパンツ

## テキスト

Монгол үндэсний их баяр бол наадам юм. Жил бүрийн 7-р сарын 11-13-ны өдрүүдэд болдог. Монгол баяр наадмын хамгийн гол цэнгэл нь эрийн гурван наадам гэж алдаршсан хурдан морь, хүчит бөх, эрхий мэргэн харваа билээ. Улаанбаатар хотын төв цэнгэлдэх хүрээлэнд таван зуун арван хоёр бөх барилдана. Хүчит бөхийн барилдаанд тав давбал начин, зургаа давбал харцага, долоо давбал заан, найм давбал гарьд, ес давбал арслан, аварга цол хүртэнэ. Бөхчүүд уран мэхээрээ наадмын зүлэг ногоон дэвжээнээ хүчээ үзэхийг харах сайхан. Сурын талбайд харваачид цэцээ сорьдог. Халх, буриад, урианхай сурын харваагаар эрэгтэй, эмэгтэй сурчид сумаа тавьж, нумаа татах бахтай. Монгол үндэсний сур харвааны бай нь хана сур, хасаа сур билээ. Урианхай сур хавчаахай нумаар харвадгаараа халх буриад сураас ялгаатай. Наадмыг хурдан морьгүйгээр төсөөлөмгүй. Хүй долоон худгийн хөндийд морь уралддаг. Их нас азарга, соёлон, хязаалан, дааганы уралдаанд олон зуун морь унасан хүүхэд, уясан эзнээ баясган хурдаа сорино. Ялангуяа соёолонгийн тоос хийморь сэргээдэг. Бяцхан дааганы уралдаан өхөөрдөм хөөрхөн. Монголчууд эрүүл явбал улсын наадам үзнэ гэдэг. Аз жаргал төгс монгол түмний наадам улам өнгөлөг байх болтугай.

## 練習問題

(1) 問いに答えなさい。

1/ Монгол үндэстний их баяр юу вэ?

.....

2/ Хүчит бөхийн барилдаанд хэд давбал начин цол хүртэх вэ?

.....

3/ Хүчит бөхийн барилдаанд хэд давбал харцага цол хүртэх вэ?

.....

4/ Хүчит бөхийн барилдаанд хэд давбал заан цол хүртэх вэ?

.....

5/ Хүчит бөхийн барилдаанд хэд давбал гарьд цол хүртэх вэ?

.....

6/ Хүчит бөхийн барилдаанд хэд давбал арслан цол хүртэх вэ?

.....

7/ Хүчит бөхийн барилдаанд хэд давбал аварга цол хүртэх вэ?

.....

8/ Хаана хэдэн бөх барилддаг вэ?

.....

9/ Хаана морь уралддаг вэ?

.....

10/ Ямар уралдаан өхөөрдөм хөөрхөн бэ?

.....

11/ Монголчууд амьд явбал яана гэдэг вэ?

.....

(2) 語を補いなさい。

1/ Жил ..... 7-р.....11-13-ны ..... болдог.

2/ Монгол .....наадмын..... гол..... нь..... гурван .....

гэж ..... хурдан ....., хүчит ....., эрхий ..... харваа .....

3/ .....дааганы..... өхөөрдөм .....

4/ Их ..... азарга,....., хязаалан,.....уралдаанд олон..... морь

унасан ....., уясан..... баясган..... сорино.

語句 (2)

азарга

種馬

алдарш-	有名になる
арслан	ライオン（モンゴル相撲の称号）
бай	的（まと）
барилд-	相撲をとる
бах	喜び、楽しみ
баясга-	喜ばす
болтугай	成るように
бяцхан	小さい
гарьд	鳳凰（モンゴル相撲の称号）
дав-	勝つ
дэвжээ	土俵
зүлэг	草地
начин	はやぶさ（モンゴル相撲の称号）
ногоон	緑の、青々とした
нум	弓
өнгөлөг	色彩豊かな
өхөөрдөм	かわいらしい
сорь-	試す
сум тавь-	矢を放つ
сур харваа	弓矢で射ること
сурч	射手
сэргээ-	覚ます
тоос	埃
төгс	満ちた

түмэн	人々
улам	さらに
уран	巧みな
хавчаахай	エビ
хана сур	的（革紐）の壁
харва-	射る
харваач	射手、弓手
харцага	オオタカ（モンゴル相撲の称号）
хасаа сур	削除の的
хийморь	幸運
хөндий	広い谷あい
хөөрхөн	愛らしい、美しい
хүрт-	頂く、受ける
хүч үз-	力を試す
хүчит	力強い
цол	称号、位
цэнгэл	楽しさ、喜び、娯楽
цэнгэлдэх хүрээлэн	スタジアム
цэц	ものの本質、確かさ、命中率
цэц сорь-	命中率を試す
эзэн	主人、持ち主
эрийн гурван наадам	丈夫の三つの競技
эрүүл яв-	健康でいる
эрхий мэргэн	巧みな射手

ялгаатай

違いがある

## 参考文献 (Ном зүй)

Баттуул Д., (2013) *Монгол хэлний яриа ба сорил*, Улаанбаатар.

Буянцогтоо Ц., (2013) *Япон хэл сонирхогчийн өврийн ном*, Улаанбаатар.

Пүрэвжанцан А., (2013) *Монгол хэлний үгийн сан, уншлага*, Улаанбаатар.

Сэржээ Ж., (2011) *Монгол орон судлал*, Улаанбаатар.

Хашимото М., Пүрэвжав Э., Туяа Ж., (1996) *Монгол япон хэлний яриа*,  
Улаанбаатар.

Munkhtsetseg, G., Delgermaa, Kh., (2008) *Golden Key to Mongolian*, Ulaanbaatar.

橋本勝 (2010) 『ニューエクスプレス モンゴル語』 白水社.

橋本勝 (監修) ・塩谷茂樹 (編) (1993) 『モンゴル語会話・読解』 東京外国  
語大学AA研.

橋本勝・E. プレブジャブ (編) (1993) 『モンゴル文語』 東京外国語大学AA  
研.

B. ルハッグワール・橋本勝 (1989) 『実用中等モンゴル語』 大阪外国語大学.

Mongolian Conversation and Reader  
ILCAA Intensive Language Course 2015: Mongolian, Textbook 1

モンゴル語会話・講読  
平成 27 年度言語研修 モンゴル語研修テキスト 1

平成 27 年 7 月 27 日 発行

著者 橋 本 勝  
M. オーガンバヤル

発行 東京外国語大学  
アジア・アフリカ言語文化研究所  
〒183-8534 東京都府中市朝日町 3-11-1  
TEL. 042-330-5600

印刷 日本ルート印刷出版株式会社  
〒135-0007 東京都江東区新大橋 1-5-4  
TEL. 03-3631-3861

©Masaru HASHIMOTO, Myagmarsuren UUGANBAYAR  
ISBN 978-4-86337-203-0